

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-12

1.Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан
“Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С
компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл
/Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/ 3-12

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 42 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Дэлгэрсайхан, Х.Жангабыл, Д.Цогтбаатар, Ө.Шижир, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр.

Нэг.Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга Г.Манлайжав, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Мон-Атом” ХХК-ийн захирал Д.Далайжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, гэрээний төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар тус тус танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагайгийн тавьсан асуултад Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга Г.Манлайжав хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6

Бүгд: 19
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн “Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 19
73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 33 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
16 цаг 42 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Ирцийг та бүхэнд танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн хүрэлцэн ирсэн байна, Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Энхтайвангийн Бат-Амгалан гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал 1 байгаа. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл, Засгийн газар 2025 оны 1 сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх гэдэг энэ асуудал байгаа. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Алга байна.

Тэгвэл хэлэлцэх асуудалдаа орцгооё. Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компани ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг САС компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хэлэлцэж эхэлье. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг та бүхэнд танилцуулъя. Ойлголоо. Би энд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, ажлын хэсгийн дарга Ням-Осорын Учрал гишүүн, залгуулаад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Мон-Атом компанийн захирал Доржбалын Далайжаргал, ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай. Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал Санжаагийн Наранцогт, Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Бат-Эрдэнийн Хулан, Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи ашиглалтын газрын дарга Сэр-Одын Ган-Очир зэрэг ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуралдаанд ирсэн байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг САС компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний талаарх танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, ЗГХЭГ-ын дарга ажлын

хэсгийн ахлагч Ням-Осорын Учрал сайд танилцуулна. Таныг микрофонд урьж байна. 5 номер.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Орано Майнинг САС компанийн хооронд байгуулах уран олборлох төслийн хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Монгол Улсын эрх ашиг хууль тогтоомжид нийцүүлэн хөрөнгө оруулагч талтай урьдчилан тохирч боловсруулж, Цөмийн энергийн тухай хуулийн 30.3-д заасны дагуу зөвшилцөхөөр танилцуулж байна. Зөөвч-Овоо Дулаан-Уулын ураны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах энэхүү төсөл нь хамтарсан Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн улсын хөгжлийн бүтээн байгуулалтын 14 мега төслийн 1 бөгөөд энэхүү гэрээг хэрэгжүүлснээр гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, улс, орон нутгийн төсөвт хөрөнгө төвлөрүүлэх, ажлын байрыг бий болгох, шинэ технологи нутагшуулах, мөн олон улсын хамтын ажиллагаа зэрэг нийгэм, эдийн засагт үзүүлэх шууд нөлөөллөөс гадна, цаашид уул уурхай ашигт малтмалын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын гэрээнд жишиг тогтоох үр дагавартай.

Хөрөнгө оруулагч нь Монгол Улсад 1997 оноос хойш хайгуул олборлолтын чиглэлээр тасралтгүй 27 жил үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2021 оны 7 дугаар сараас Зөөвч-Овоо ордын үйлдвэрлэлийн туршилтын ажлыг эхлүүлж, 2022 оны 12 дугаар сард амжилттай хэрэгжүүлж дууссан. 2023 оны 5 дугаар сараас эхлэн Монгол Улсын Ерөнхий сайдын хэд хэдэн захирамжаар Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн хэлэлцээ хийж, эцэслэн боловсруулсан хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгүүд, тус ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаач, хөндлөнгийн төлөөлөл бүхий өргөн бүрэлдэхүүнтэй ажлын дэд хэсгүүдийг гэрээ, эрх зүй, эдийн засаг, хөрөнгө оруулалт, татвар, санхүү, олборлолт, үйлдвэрлэл, технологи, байгаль орчин, орон нутаг гэсэн 5 чиглэлд байгуулж хэлэлцээг үргэлжлүүлэн эцэслэсэн хувилбарыг боловсруулан ажиллалаа.

Ажлын хэсгээс гэрээний төслийн хувилбарыг боловсруулахдаа Монгол Улсын эрх ашигт нийцсэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа дийлэнх үр өгөөж ард түмэнд ноогдож байх, талуудын хүртэх өгөөжийг тэнцвэртэй хангах суурь зарчмуудыг хатуу баримталж, ирээдүйд аливаа эрх зүйн үр дагаваргүй хэрэгжих боломжийг бүрдүүлэх, цаашид жишиг гэрээ болох нөхцөлийг хангахад анхаарч ажиллалаа. Мөн энэ чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий мэргэшсэн санхүү, хууль, байгаль орчны зөвлөхүүд болон дотоодын зөвлөхүүдтэй хамтран ажилласныг онцлон тэмдэглэе.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн суурь зарчмыг баримтлан хөрөнгө оруулагчтай нийт 18 удаагийн хэлэлцээг хийж, Монгол Улсын эрх ашиг Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд нийцүүлэн боловсруулсан. Тухайлбал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар ахлуулсан ажлын дэд хэсэг ажиллаж, цацрагийн хяналт, аюулгүй ажиллагааны талаар дараах нөхцөлүүдийг урьдчилан тохиролцсон. Олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлж, байгаль орчны хяналт мониторинг гүйцэтгэхэд олон нийтийн оролцоог хангаж, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны стандартыг мөрдөж ажиллах. Олборлолт, үйлдвэрлэл нь үндэсний лабораторийн

хяналтад байх бөгөөд Олон улсын байгууллагаар тогтмол аудит хийлгэх. Гол түүхий эд болох хүхрийн хүчлийг дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжийг бүрдүүлэх. Ордыг бүрэн ашиглах, үйлдвэрлэлийн хэмжээг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх, хэт бууруулах, нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг үндэслэлгүйгээр түр зогсохоос сэргийлэх, цацраг идэвхт хаягдлыг уурхайн талбайд ангилах, ялгах, боловсруулах, аюулгүй булшлах эдгээр үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчны нөхөн сэргээх асуудлыг төсөл хэрэгжүүлэгч компани бүрэн хариуцах, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон суурь үзүүлэлтүүдийг ашиглан төслийн бүх үе шатад байгаль орчны мониторинг, гео экологийн судалгаа, цацрагийн хяналтыг хэрэгжүүлж, 3 жил тутамд төслийн үйл ажиллагаа болон технологидоо олон улсын атомын энергийн агентлагийн шинжээчдээр хөндлөнгийн аудит хийлгэх.

Хөрөнгө оруулалтын гэрээнд хууль тогтоомжийг тогтворжуулахгүй, зөвхөн хуульд орсон өөрчлөлт нь төслийн компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх буюу 5 жилийн хугацаанд хуульд орсон өөрчлөлт нь төсөл хэрэгжүүлэгч компанийн зардлыг 10 хувиар өсгөсөн тохиолдолд талууд хэлэлцээрт орох, хөрөнгө оруулагч гэрээнд заасан нөхцөлийн дагуу хөрөнгө оруулалт хийх болон төсөл хэрэгжүүлэх үүргээ зөрчсөн тохиолдолд Монгол Улсын Засгийн газар гэрээг цуцлах нөхцөлийг гэрээнд тусгалаа.

Энэхүү хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж хэрэгжүүлснээр улс орон нутгийн төсөвт жилд 520 тэрбум, төслийн нийт хугацаанд 17,1 их наяд, Үндэсний баялгийн санд жилд 61,5 тэрбум, төслийн нийт хугацаанд 2 их наяд төгрөгийг төвлөрүүлж, 1600 орчим ажлын байрыг шинээр бий болгож, шинэ технологийг нутагшуулж, хүхрийн хүчлийн үйлдвэр зэрэг бүтээн байгуулалт хийгдэх боломж бүрдэх болно. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, төсвийн орлого, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, дэвшилтэт технологи, мэдлэг туршлагыг нэвтрүүлж, шинэ төрлийн үйлдвэрийг хөгжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлж, мэргэшсэн боловсон хүчний нөөц бүрдүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг бий болгохоос гадна Монгол Улс стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн экспортлогч орон болж, улмаар ураны зах зээлийн гол тоглогчдын нэг болох, нүүрсхүчлийн хий ялгаруулдаггүй цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэх эхлэл тавигдах болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Орано Майнинг САС компанийн хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхөөр та бүхэнд танилцуулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Учрал сайдад баярлалаа. Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жаргалан гишүүн танилцуулна. Таныг микрофонд урьж байна. Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи

компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг САС компанийн хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ. Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх гэрээний төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Төсөл санаачлагчийн зүгээс уг гэрээг Монгол Улсын эрх ашигт нийцсэн, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа дийлэнх үр өгөөж ард түмэнд ноогдож байх, талуудын хүртэх үр өгөөжийг тэнцвэртэй хангах суурь зарчмуудыг баримтлан хөрөнгө оруулалтын гэрээг байгуулснаас хойш 4 жилийн хугацаанд хийхээр тусгаж, олон улсын фааст стандартын дагуу Монголын тал өөрийн санхүүгийн тооцооллын загварыг боловсруулж, хөрөнгө оруулагчтай тулган баталгаажуулалт хийсний үндсэн дээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын өгөөжийн 51-ээс доошгүй хувийг хуримтлагдсан дүнгээр Монгол Улс жил бүр хүртэх тооцооллыг баталгаажуулахаар тус тус тохиролцсон болохыг дурдсан.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг томоохон төслүүдийн ач холбогдлыг олон нийтэд зөв ойлгуулж хүргэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг хөрөнгө оруулалтын гэрээ болон хувьцаа эзэмшигчдийн гэрээнд хөрөнгө оруулалттай холбоотой зохицуулалтуудыг нарийвчлан тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд гэрээ байгуулахдаа борлуулалтын үнэ, үнэлгээний тооцооллын анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг байгаль орчны нөхөн сэргээлтийн зардлын хэмжээг хэт бага тусгасан байгааг анхаарах, гэрээнд хаалтын барьцааны асуудлыг тодорхой тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн компанийн хувьцаа болон тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хязгаарлахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийг гэрээний төсөлд оруулах, бүтээгдэхүүний 10-аас доошгүй хувийг тухайн компанитай ижил нөхцөлтэйгөөр худалдаж авах эрхтэй байх зохицуулалтыг өөрчлөлт найруулах, уурхайн ашиглалтын явцад ажиллах Монгол ажилчдын 51-ээс доошгүй хувь нь тухайн аймаг, сумдын иргэн байх, мөн орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг туслан гүйцэтгэгчээр заавал оролцуулах асуудлыг гэрээнд тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Сэддорж нисэх онгоцны буудал, авто зам байгуулах зэргээр орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл учруулахгүй байх асуудлуудыг анхаарах, орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжиж хамтран ажиллах шаардлагатай талаар тус тус саналаа хэлсэн болно.

Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг САС компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулсан Жаргалан гишүүнд баярлалаа. Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар гишүүн танилцуулна. Таныг микрофонд урьж байна.

Н.Наранбаатар: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг САС компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороотой зөвшилцөхөөр ирүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх хөрөнгө оруулалтын гэрээний зөвшилцөх асуудлыг хэлэлцсэн бөгөөд Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Чинбүрэн, Уянга, Батжаргал, Ундраа, Ганбаатар, Идэрбат, Наранбаатар, Эрдэнэбат, Замира нар асуулт асууж, үг хэлсэн болно.

Хөрөнгө оруулалтын гэрээнд олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлж, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартын дагуу хангахаар усны нөөц, горим, чанарын төлөв байдлын өөрчлөлтөд байнгын ажиглалт, хяналт, шинжилгээ хийж, хяналт тавихаар, энгийн болон аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу ангилан ялгаж, дахин боловсруулах, цацраг идэвхт хаягдлыг уурхайн талбайд ангилах, ялгах, боловсруулах, аюулгүй булшлахтай холбоотой байгаль орчны нөхөн сэргээх асуудлыг хариуцан гүйцэтгэх техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон суурь үзүүлэлтүүдийг ашиглан төслийн бүх үе шатад байгаль орчны мониторинг, геоэкологийн судалгаа, цацрагийн хяналтыг хэрэгжүүлэх, байгаль орчин, усны хяналт, мониторингийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангахаар тусгасан байна.

Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг САС компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг зөвшөөрч, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг САС компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөх асуудлаар гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа, Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулсан Наранбаатар гишүүнд баярлалаа. Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг та бүхэнд миний бие танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр ирүүлсэн. Төсвийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн дагуу дээрх хөрөнгө оруулалтын гэрээний зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Хөрөнгө оруулалтын гэрээнд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, гаалийн тарифыг тогтворжуулах, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг үндсэн болон нэмэгдүүлсэн хувиар тооцох болон тусгай төлбөрийг бүтээгдэхүүн борлуулалтын үнэлгээнээс хасагдуулан инфляцад тооцохгүйгээр бүрэн төлөхөөр тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, Заяабал, Даваасүрэн нар төслийн техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан эсэх, төрийн эзэмшлийн 34 хувийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон тусгай нэмэлт төлбөрөөр орлуулсантай холбоотойгоор бий болгох цэвэр ашиг болон татварын тооцооллын талаар, know how-ын төлбөрийн хувь хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар гэрээний хөрөнгө оруулалтын хэмжээ, төслийн үйл ажиллагаанд хэрэглэх усны төслийн талаар болон хүхрийн хүчлийн уусмалыг газрын гүн рүү шахсанаар байгаль орчинд нөлөөлөх эрсдэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг төслийн хугацаанд төлөгдөх ус ашигласны нийт төлбөрийн хэмжээ болон давхар татварын гэрээний зохицуулалтын гэрээнд суутган тооцох татвар, өгөөжийн тооцоолол, төсөл хэрэгжих хугацааны талаар, мөн Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар know how-ын төлбөр, маркетингийн төлбөр нэмэгдсэнээр өгөөжид нөлөөлөх эсэх, гэрээний талууд 10 хувийн бүтээгдэхүүнийг адилхан нөхцөлөөр худалдан авах зохицуулалтын талаар асуулт асуулаа.

Улсын Их Хурлын гишүүн Батжаргал хуулиар зохицуулсан асуудлыг гэрээнд өөрөөр тусгасныг анхаарч, энгийн 34 хувийн хувьцааг 10 хувийн давуу эрхийн хувьцаагаар дүйцүүлэх талаарх гэрээний заалтуудыг боловсронгуй болгох, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар хөрөнгө оруулагч тал гэрээний хугацаанд хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллах, байгалийн баялгийг иргэдэд өгөөжтэй байлгахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн гэрээний төсөл нь өгөөжийн тохируулга хийж, зээлийг хязгаарласан боловч маркетинг менежментийн төлбөрийн талаар анхаарч, байгалийн баялгаас иргэдийн хүртэх өгөөжийг тодорхой тусгах талаар үг хэлсэн болно.

Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдлын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа гэсэн ийм санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооноос ирүүлсэн байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад тус гэрээний төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Алтаншагай, Ганбат гишүүнээр тасалъя. Үг байгаа, дараа нь хэлж болно. Алтаншагай гишүүн асуулт асууя.

Н.Алтаншагай: Өдрийн мэнд хүргэе. Гэрээний байгаль орчныг хамгаалах чиглэлээр гэсэн энэ хэсэг дээр цацраг идэвхт хаягдлын уул уурхайн талбайд ангилан ялгах, боловсруулах, аюулгүй булшлах, эдгээр үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчны нөхөн сэргээлт хийх асуудлыг хариуцаж гүйцэтгэх гэсэн байгаа юм. Өглөө Туваан сайдын ярилцлага дээр харагдах шиг болдог юм. Энэ хог хаягдлаа бэлэн бүтээгдэхүүн болоод гарсан хог хаягдлыг буцаж энэ олборлосон газар нь булшилна гэж би ойлголт авсан. Энэ дээр нэг яг тоймтой хариултыг өгөөч.

Иргэдийн дунд байгаа нэг мэдээлэл байгаад байгаа нь энэ байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой, дээр нь ураны энэ шар нунтаг нь булшлах тал дээр нэлээн эргэлзээтэй байгаа. Энэ дээр яг нэг тодорхой мэдээллийг өгөөч. Бэлэн бүтээгдэхүүн болоод гараад, ашиглагдсан ураны хог хаягдлыг эргэж Монголд авчирч булшилна гэсэн ийм ойлголт явагдсан шүү. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Г.Тэмүүлэн: Алтаншагай гишүүний асуултад ажлын хэсгийн зүгээс хариулъя. Товч бөгөөд тодорхой хариулъя. Номер 1. Цөмийн энергийн комиссын дарга Манлайжав.

Г.Манлайжав: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга Манлайжав. Нийгэмд иймэрхүү ойлголтууд сүүлийн 10 жилд байсан. Энэ бодит мэдээллээс шинжлэх ухаанаас бол хол хөндий буруу ойлголт байсан. Тэгэхээр энийг залруулах талаар нэлээд ажлуудыг уг нь хийсэн бид нар. Өнгөрсөн оны 11 сард манай Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж батлуулахад энэтэй холбоотой бүтэн заалтыг бол албан ёсоор оруулж өгсөн. Энд болохоор гаднын орны цацраг идэвхт хаягдлыг Монгол Улсын хилээр дамжин нэвтрүүлэхгүй, дамжин өнгөрүүлэхгүй, булшлахгүй гэдэг. Тэгэхээр бид шар нунтгийг экспортолно, шар нунтгийг бол 2, 3 шатын дараа цөмийн түлш болдог. Энэ түлшийг ашиглаад цөмийн цахилгаан станцад ашиглаад тэрнээс гарсан цацраг идэвхт өндөр идэвхтэй ашигласан түлшийг Монгол Улс авах тийм үүрэг байхгүй. Зохицуулалт байхгүй. Олон улсын гэрээ конвенцод тийм зүйл байхгүй. Тэгэхээр энийг зүгээр ташаа ойлголт байсан. Тийм учраас бид энэ дээр хуульдаа бид заалтуудаа тусгасан. Энэ хэлэлцээр дээр ч гэсэн тодорхой заалтууд байгаа. Тийм учраас энэ дээр бол санаа зоволтгүй байж болно гэж.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Алтаншагай гишүүн болсон байх тийм ээ? Ганбат гишүүн нэрээ татсан байна, чуулган дээр орж асуултаа асууя гэж байна. Энхнасан гишүүн чуулган дээр яах уу? Тэгье, чуулган дээр асууя. Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Гэрээний төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Алга

байна. Санал хураалт явуулах байгаад байгаа. Хэд хэдэн асуудлаар 1 дүгээрт санал хураана.

1 дүгээрт ийм асуудал байгаа. Байнгын хорооны гишүүд анхааралтай байгаарай. Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлд гэрээний төслийн агуулга, ач холбогдлыг харгалзан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэж болно гэж заасан байгаад байгаа юм. Тэгэхээр манай Байнгын хорооноос энэ асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөх нь зүйтэй гэсэн саналыг гаргаж болохоор байгаад байгаа. Тэгээд 1 дүгээр асуудал энэ асуудлаар санал хураахаар байгаад байгаа. Тэгээд хэрэв Байнгын хорооны гишүүдийн олонх нь нэгдсэн чуулганы хуралдаанд оруулах нь зүйтэй гэж үзвэл манай Байнгын хорооны саналын хүрээнд чуулганд оруулж болно.

Тэгэхээр эхний асуудал Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээ төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураахаар байгаад байгаа. Энэ асуудлаар саналыг хураая. Гишүүд анхааралтай байж саналаа өгөөрэй. Нэгдсэн хуралдаанаар оруулж, хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн хувь хүний байр суурь байна. Санал хураалтыг явуулъя. Санал хураалтад нийт 19 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжлээ. Ингээд 68,4 хувиар нийт гишүүдийн олонх нь чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

2 дахь санал хураалт. Энэ үндсэн манай Байнгын хорооноос хураах саналын томьёолол байгаад байгаа. Энэ маань Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулна. Гишүүд анхааралтай байж байгаад санал хураалтад идэвхтэй оролцоорой. Санал хураалтыг явуулъя. Гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулна. Баярлалаа. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжсэн байна. Батсүмбэрэл гишүүн дэмжсэнээр саналаа өгч байна. 19 гишүүнээс 12 гишүүн дэмжсэн байна.

3 дахь асуудал байгаа. 3 дахь асуудал чуулган руу Байнгын хорооны санал, дүгнэлтийг оруулахтай холбогдуулаад Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэсэн бол Улсын Их Хурлын тогтоолын төслийг санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасан байгаад байгаа юм. Тэгэхээр энэ заасны дагуу нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хурлын тогтоолын төслийг оруулахаар байгаад байгаа.

Тэгээд би та бүхэнд саяын санал хураалт дэмжигдсэнтэй холбогдуулаад тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын

тогтоол. Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компанитай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхөөр ирүүлснийг Улсын Их Хурлын 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөн тооцсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байгаад байгаа юм. Энэ тогтоолын төслийн талаар санал хураалт явуулна. Санал хураалт явуулахын өмнө зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байгаа юу? Та микрофонд хэлэх үү? Ажлын хэсгийн ахлагч Учрал сайд тогтоолын төслийн талаар чуулганд оруулах Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар санал байна уу? 5 номер.

Н.Учрал: Цөмийн энергийн хуулийн дагуу зөвшилцөхөөр танилцуулж байгаа. Тэгэхээр сая яг энэ гэрээг хэлэлцэхтэй холбогдуулаад 1 удаагийн дэгийг баталсан. Дэг дээр 3 заалт байгаа. Бүтнээр нь дэмжих, тэгээд бүхлээр нь дэмжих гэж. Тэгэхээр сая болохоор нөгөө 3 Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдлын байнгын хороонд танилцуулаад, энэ хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцсөн учраас гэрээг байгуулахыг Монгол Улсын Засгийн газарт зөвшөөрсүгэй гээд сая санал хураалт болчихлоо гэж би ойлголоо шүү дээ. Тэгэхээр санал хураалт болчихсон учраас тогтоол дээрээ зөвшилцсөнд тооцсугай. Тэгээд нөгөө Засгийн газрын зүгээс Орано Майнинг компанитай хөрөнгө оруулалтын гэрээ хийхийг Монгол Улсын Засгийн газарт зөвшөөрсүгэй гэдэг тогтоол гарахгүй бол энэ 2 хоорондоо зөрчилдөөд байгаа юм биш үү л гэж бодоод байна л даа. Тэгэхээр түрүүний санал хураалт уг нь болсон гэж ойлгосон.

Г.Тэмүүлэн: Та бол гэрээнд гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгосугай гэсэн ийм үг, үсгээр найруулгыг хийе гэсэн саналтай байх шиг байна. Бид яг энэ саналаар санал Байнгын хорооны санал, дүгнэлт бол гарч байгаа. Засгийн газарт гарын үсэг зурах эрхийг олгосугай гээд. Ингээд Байнгын хорооноос албан бичгээр тодорхой тогтоолоор энэ шийдвэр нь хүргэгдэхээр байгаад байгаа.

Энэ Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаад байгаа юм. Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр үндсэндээ Улсын Их Хурал зөвшилцөх үүрэгтэй байгаад байгаа юм. Тэгээд нэг талдаа энэ компани хоорондын харилцаа, арилжааны гэрээтэй холбоотой асуудал дээр бид тодорхой Засгийн газраас зөвшилцөх энэ гэрээний төслийг өчигдөр авсан. Ингээд үндсэндээ танилцаад, Байнгын хороо танилцаад, өнөөдөр хэлэлцээд, тогтоолынхоо төслийг зөвшилцсөнд тооцсугай гэдэг томъёоллоор оруулж ирж байгаа. Дэгийн тухай хуулиар ийм тодорхой үг, үсэг заалттай байна гэж ойлгож энэ тогтоолын төслийг боловсруулж оруулж ирсэн.

Тэгээд ямар ч бай, сая Байнгын хорооны гишүүдийн олонх нь Засгийн газрыг гэрээнд гарын үсэг зурах эрх олгохыг дэмжсүгэй гэсэн шийдвэрийг гаргасан байгаад байгаа. Улсын Их Хуралд оруулах тогтоолын төслийг бид ямар ч бай зөвшилцсөнд тооцсугай гэдгээр оруулчаж байгаа юм. Энэ би зарчмын хувьд зөв

байх гэж ойлгож байна. Тэгвэл ингээд явчихлаа гэж ойлголоо шүү Учрал сайдаа. Энэ асуудлаар санал хураалтыг явуулъя. Өөр саналтай гишүүд бол байхгүй байх тийм ээ? Би тогтоолын төслийг уншаад танилцуулчихсан байгаа.

Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн хэлэлцүүлгийг, тогтоолын төслөөрөө санал хураалтыг явуулна. Саяын уншсан тогтоолын төслийн хүрээнд санал хураалтыг явуулъя. Гишүүд бол ойлгосон, тодруулах лавлах асуулт байхгүй тийм ээ? Тэгвэл тогтоолын төслийг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжсэн. Ганбат гишүүн гараа өргөж байна. Батсүмбэрэл гишүүн бас гараа өргөж дэмжиж байна. Нийт 19 гишүүнээс 14 гишүүн дэмжсэн байна.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүнийг томилъё. Энхтүвшин, Алтаншагай гишүүн. Алтаншагай гишүүнийг томилж байна. Алтаншагай гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна. Монгол Францын хамтарсан Бадрах Энержи компанийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсэгт баярлалаа. Байнгын хорооны гишүүдэд баярлалаа.

17.15 цаг

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА